



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 5/42

Хэрлэн сум

Б.Атарбаярыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Бүрнээбаатарын Атарбаярыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн “Монгол Хатдын өргөө цогцолбор” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Ууганцэцэг

“Монгол Хатдын өргөө цогцолбор” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын тайлбарлагч

3.Б.Атарбаярын цалинг TY-9 зэрэглэрээр адилтган тооцож олгохыг зөвшөөрсүгэй.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Б.Атарбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

